



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

2023 оныг “Иргэдийн оролцоо,
сахилга хариуцлагыг дээшлүүлэх жил”
болгон зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, нийслэл, дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, иргэдийн санал санаачилга, идэвх оролцоог дэмжих, төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг сайжруулах, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор дүүргийн хэмжээнд 2023 оныг “Иргэдийн оролцоо, сахилга хариуцлагыг дээшлүүлэх жил” болгон зарласугай.

2.Зорилтот жилийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг шуурхай зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд аж аж ахуйн нэгж, байгууллага, хувийн хэвшил, иргэдийн саналыг тусган боловсруулж, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахыг Ажлын хэсэг (Б.Болормаа)-т үүрэг болгосугай.

4.Зорилтот жилийн хүрээнд зохион байгуулах арга хэмжээг байгууллага, нэгж бүр гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган, иргэдийн оролцоог хангах, дэмжих ажиллах чиглэлээр үр дүнд чиглэсэн ажил зохион байгуулахад үйл ажиллагаагаа уялдуулж, байгууллага, албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд анхаарч ажиллахыг Аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.


5.Зорилтот жилийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар ханган, явц үр дүнг хагас жил, жилийн эцсийн байдлаар дүгнэн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж, үйл ажиллагааны талаарх мэдээллийг иргэд, олон нийтэд тогтмол хүргэн, сурталчилж ажиллахыг Ажлын хэсэг (Б.Болормаа)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны...сарын...-ны өдрийн... дугаар
захирамжийн хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч
Гишүүд:	Засаг даргын зөвлөх Засаг даргын Тамгын газрын дарга Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (зөвшилцсөнөөр) Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга Цэргийн штабын дарга 1 дүгээр хорооны Засаг дарга 2 дугаар хорооны Засаг дарга Дотоод аудитын албаны дарга Худалдан авах ажиллагааны албаны дарга Газар зохион байгуулалтын албаны дарга Боловсролын хэлтсийн дарга Татварын хэлтсийн дарга Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн дарга Онцгой байдлын хэлтсийн дарга Цагдаагийн хэлтсийн дарга Жижиг дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих төвийн захирал Багахангай өртөөний дарга
Нарийн бичгийн дарга:	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга